



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 322

Улаанбаатар хот

“Юу Би Би Ди” ХХК-ийн  
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.4, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30.1.2, 63.1.5 дахь заалт болон Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 11.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Юу Би Би Ди” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Юу Би Би Ди” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авах, баримт хүлээлцэх ажлыг зохион байгуулж, арилжаа эрхлэх, төлбөр тооцоо хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын төлөөлөл бүхий комисс томилон ажиллуулахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/-т үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон компанийн хэлцлийн жагсаалтыг үндэслэн харилцагчийн үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаатай холбоотой баримтыг “ҮЦТТГХТ” ХХК /Т.Гандулам/, арилжаа болон санхүүгийн баримтыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/-д өөрийн архивт хүлээн авахыг тус тус үүрэг болгосугай.

4. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсонтой холбогдуулан харилцагчийн арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн баримтыг холбогдох журамд заасны дагуу цэгцлэн архивын нэгж болгон арилжаа эрхлэх болон төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын архивт хүлээлгэн өгөхийг “Юу Би Би Ди” ХХК /Г.Оргилмаа/-д үүрэг болгосугай.

5. Тус Компанийн харилцагчдыг брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бусад компанид шилжүүлэх асуудлыг Хорооны 2008 оны 221 дүгээр тогтоолоор батлагдсан “Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компанийн харилцагчдыг шилжүүлэх тухай журам”-ын дагуу шийдвэрлэхийг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийт, харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

00 348